



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН,
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

ШУТИС-КООСЭН ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖ



ШУТИС-КООСЭН ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖ

Асуудлыг бүтээлчээр шийдье

ШУТИС-КООСЭН ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖ





АГУУЛГА

- Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс
- Захирлын мэндчилгээ
- Манай хөтөлбөрүүд
- Манай статистик
- Гадаад харилцаа, хамтын ажиллагаа
- Оюутны сэтгэгдэл
- Дугуйлан, клуб
- Сургалтын орчин

АЛСЫН ХАРАА:

Дэлхийд үнэлэгдэх оюуны үнэ цэнийг бүтээнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Эх орны хөгжлийн гарцыг тодорхойлох хүн-байгальд ээлтэй шинжлэх ухаан, технологийн мэдлэг, инновацийг бүтээх авьяас чадварын төвлөрөл байна.



ҮНЭТ ЗҮЙЛС



ШИЛДЭГ ГҮЙЦЭТГЭЛ



УЛАМЖЛАЛ



ТЭМҮҮЛЭЛ



ИННОВАЦИ



САЙН-ХҮМҮҮНЛЭГ ЗАСАГЛАЛ



ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

ШУТИС-Коосэн Технологийн коллежид тавтай морилно уу

Япон улсын Коосэн загварын инженер, технологийн сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааны менежмент манай сургуульд хэрэгжээд 9 жил өнгөрч байна. 15 настай хүүхдүүд гараараа бүтээх, хийх сонирхол дээр тулгуурлан Япон улс тэртээ 1960 оноос энэхүү боловсролын тогтолцоог бий болгосон бөгөөд энд төгссөн инженерүүд аж үйлдвэрлэл хөгжихөд ихээхэн хувь нэмэр оруулсан түүхтэй.

Инженер технологийн салбарт мэргэшсэн боловсон хүчин эрэлт ихтэй байгаа энэ үед манай сургууль Япон улсын боловсролын шилдэг туршлагыг нэвтрүүлж, барилга, механик, цахилгааны инженерчлэлийн хөтөлбөрөөр дунд түвшний дээд боловсролтой инженерүүдийг бэлтгэн хөдөлмөрийн зах зээлд гаргаж байна. Манай оюутнууд 20 насандаа инженер болж төгсдөг бөгөөд их сургуулийн 3-р курсээс үргэлжлүүлэн суралцах, шууд ажлын байранд гарах, Япон улсын их, дээд сургуульд дэвшин суралцах, Японы компанид ажиллах бүрэн боломжтой байдаг нь Коосэн загварыг инженерийн боловсролын тогтолцооны давуу тал, онцлог юм.

Сургалтын хөтөлбөрийн тухайд ерөнхий эрдмийн хичээлүүдийн агуулга нь мэргэжлийн хичээлийн агуулгатай нягт уялдах бөгөөд хичээлүүд онолын мэдлэгээс гадна практик дадлага хийлгэх байдлаар хослуулан мэдлэг олгох, түүнийгээ турших, бүтээх, дадлага хийлгэх зэргээр инженер хүнд байх үр чадварыг олгож байна. Түүнээс гадна манай үндсэн сургалтын үйл ажиллагаанаас гадна хичээлээс гадуурх дугуйлан, клубийн үйл ажиллагаа маш чухал бөгөөд оюутнууд хамтран ажиллах, бүтээлч, эрэлхийлэх үр чадваруудыг энд батжуулан суралцаж олж авдаг. Тухайлбал: барилгын чиглэлээр Дизакон клуб, цахилгаан электроник, хиймэл оюун ухаан, механикийн чиглэлээр Дкон, Ганробот, инженер хүн мэдвэл зохих програм хангамж, компьютерын чиглэлээр CAD/CAM клуб хичээллэдэг бол урлаг, спортын дугуйлангууд ч мөн ажилладаг.

Манай ШУТИС-Коосэн Технологийн коллежийн оюутан, суралцагчид сониуч, бүтээлч сэтгэлгээтэй, асуудлыг бүтээлчээр шийдвэрлэгч инженерүүд болохоор шамдан суралцаж байгааг харахад бахархалтай байдаг.

Та бүхнийг манай сургуульд суралцахыг урьж байна.
Монгол улсын хөгжлийн түлхүүр инженер хүний гарт бий.

Дагвадаш ДУЛМАА

Захирал

ШУТИС-Коосэн Технологийн коллеж

МАНАЙ ХӨТӨЛБӨРҮҮД




ЦАХИЛГААНЫ ИНЖЕНЕРЧЛЭЛ ХӨТӨЛБӨР

Цахилгааны инженерчлэлийн хөтөлбөрт 9-р анги төгссөн суурь боловсролтой иргэн элсэж, ерөнхий суурь эрдмийн хичээл болон мэргэжлийн хичээлүүдийг үе шаттайгаар онол, дадлагыг хослуулан 5 жилийн хугацаанд суралцаж дүүргээд дээд боловсролын дипломын зэрэгтэй инженер болж төгсөнө.

Машин, тоног төхөөрөмжийн эд ангийн бүтээц зохион байгуулалт, тооцооллын арга аргачлалыг судалж, инженерийн шийдлийг боловсруулж, зохион бүтээх, үйлдвэрлэх, ашиглах мэдлэг үр чадвартай бүтээлч сэтгэлгээтэй инженер бэлтгэнэ.

Дараах ажлын байранд ажиллана.

- Автоматжуулалтын инженер
 - Цахилгааны инженер
 - Электроникийн инженер
-





БАРИЛГЫН ИНЖЕНЕРЧЛЭЛ ХӨТӨЛБӨР

Барилгын инженерчлэлийн хөтөлбөрт 9-р анги төгссөн суурь боловсролтой иргэн элсэж, ерөнхий суурь эрдмийн хичээл болон мэргэжлийн хичээлүүдийг үе шаттайгаар онол, дадлагыг хослуулан 5 жилийн хугацаанд суралцаж дүүргээд дээд боловсролын дипломын зэрэгтэй инженер болж төгсөнө.

Барилгын инженер мэргэжлээр суралцсанаар барилгын материал түүний шинж чанар, үйлдвэрлэх аргыг судалж түүнийг зөв ашиглах, барилгын бүтцийн талаар онолын мэдлэгтэй болж түүнийгээ практикт ашиглаж, бүтээлчээр хэрэгжүүлэх дадал, чадварыг эзэмшинэ. Мөн инженер, технологийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг зөв сонгож ажиллуулах, тэдгээрийн үр дүнг үнэлж дүгнэлт гаргах, бие даах, багаар ажиллах болон судалгаа хийх, зохион байгуулах мэдлэг чадварыг эзэмшихээс гадна хот төлөвлөлтийн суурь мэдлэг, барилгын түүх болон хууль эрх зүйн мэдлэгтэй мэргэжилтэн болно.

Дараах ажлын байранд ажиллана.

• Барилгын инженер

• Талбайн инженер

• Зургийн инженер





МЕХАНИК ИНЖЕНЕРЧЛЭЛ ХӨТӨЛБӨР

Механикийн инженерчлэлийн хөтөлбөрт 9-р анги төгссөн суурь боловсролтой иргэн элсэж, ерөнхий суурь эрдмийн хичээл болон мэргэжлийн хичээлүүдийг үе шаттайгаар онол, дадлагыг хослуулан 5 жилийн хугацаанд суралцаж дүүргээд дээд боловсролын дипломын зэрэгтэй инженер болж төгсөнө.

Механик инженер мэргэжлийн оюутнууд нь дэвшилтэт технологийн хэрэглээ, ур чадвар бүхий мэдлэг, мэдээлэл, мэргэжлийн суурь хичээлүүдийг практик төвтэй сургалтын арга аргачлалаар дамжуулан мэргэшнэ. Уг мэргэжлийг эзэмшсэнээр технологийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлж анхаарал хандуулсан, бие дааж шинэ мэдлэг, мэдээллийг олж авах бие хүн болж төлөвшинө.


Дараах ажлын байранд ажиллана.

- Механик инженер
- Зураг төслийн инженер
- Засвар механикийн инженер
- Үйлдвэрлэлийн автоматжуулалтын инженер




МАНАЙ СТАТИСТИК


Оюутнуудын өсөлт



Төгсөгчид



Төгсөгчид




ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА



Япон улсын Коосэн загварын технологийн коллежууд, компаниудтай нягт хамтын ажиллагаатай ажилладаг тул оюутнуудад Япон явж танилцах болон үйлдвэрийн дадлагаар ажиллах, оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах, Япон улсад зохиогддог олон улсын инженер, технологийн тэмцээнүүдэд оролцох бүрэн боломжтой.

Хамтран ажилладаг сургуулиуд:

- Мияконожо Технологийн коллеж
- Нагаока Технологийн коллеж
- Сэндай Технологийн коллеж
- Салежио Технологийн коллеж
- Томакомаи Технологийн коллеж
- Кисаразу Технологийн коллеж
- Хакодатэ Технологийн коллеж
- Хачинохэ Технологийн коллеж
- Сүзүка Технологийн коллеж
- Чива Технологийн Институт
- Нагаока Технологийн Их сургууль



ЯПОН ДАХЬ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГА




Хамтран ажилладаг компаниуд:

- JAL Engineering Co.,Ltd,
- ANA Base Maintenance Technics Co.,LTD,
- TOHKON Co.,Ltd,
- MCS Group
- Finechem Inc.
- NIHON SOUGEI Co.,Ltd
- GES CORPORATION
- Tanaka Consultant
- Mitsubishi Jisho Community Co.,Ltd
- Yamashita Electric Co.,Ltd
- DIC Corporation
- NTT InfraNet
- OSADA ELECTRIC CO.,LTD.



ОЮУТНЫ СЭТГЭГДЭЛ




ОЮУТАН: Б.НАРАНБАЯР

Сайн байна уу. ШУТИС-Коосэн ТК-ийн механикийн 4-р курсийн Б.Наранбаяр байна. Инженерийн мэргэжлийг эзэмших зорилготой болсон нь манай сургуулийн ач билээ. Сургуулийн маань давуу тал нь төгсөөд Японы компаниудад ажиллах боломжийг олгодог ба би энэ зуны 8 сард мэргэжлээрээ Японы “Japan Fine Ceramics” ХХК-д үйлдвэрийн дадлага хийхээр болсонд сургуульдаа мөн тус компанид талархлаа илэрхийлмээр байна.

ОЮУТАН: Б. ГАНЧИМЭГ

Сайн байцгаана уу. Намайг Б.Ганчимэг гэдэг. Би цахилгаан электроникийн 4-р ангид сурдаг. Манай сургууль Япон хэлийг 1-р ангиас заадаг бөгөөд Япон улсын компанид дадлага хийх, төгсөөд шууд ажиллах боломжтойгоороо том давуу талтай. Инженер болох зорилго тавьж энэ сургуульд орж ирсэн. Би инженерийн хичээлүүдэд онолын мэдлэг олж авч, дадлага, туршилтын хичээлээр бататган сурч байгаа тул хичээл маань маш сонирхолтой байдаг. Бидэнд олон боломж олгож өгдөг сургуульдаа маш их баярлаж байна.





DCON клуб



DEZACON клуб



Эмнэлгийн үйлчилгээ



Робокон тэмцээн

ДУГУЙЛАН, КЛУБ



Ганробот клуб



Хаврын баяр



CAD,САМ клуб



Хөгжөөн дэмжигчид клуб



СУРГАЛТЫН ОРЧИН





ХОЛБОО БАРИХ



Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль 8-р хороо, 8-р байр,
Бага тойруу, Сүхбаатар дүүрэг Улаанбаатар, Монгол улс 14191



must-kosen@must.edu.mn



www.kosentc.edu.mn



ШУТИС-КООСЭН ТК



9996 5367, 9187 1336